



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/143

Улаанбаатар хот

Маягт, түүнийг нөхөх зааврыг
зөвшөөрөх тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4, 6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн дор дурдсан захиргааны статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг хавсралтын дагуу баталж, мөрдүүлэхийг Сангийн сайд /Б.Болор/-д зөвшөөрсүгэй.

Үүнд:

1. Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... оны тайлан (З-ОУИТБС-1),
2. Газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны 20... оны тайлан (З-ОУИТБС-2),
3. Орон нутгийн төсөвт ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс төвлөрүүлсэн барьцаа, албан татвар, хураамжийн орлогын 20... оны тайлан (З-ОУИТБС-3),
4. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын төсөв, төрийн байгууллагад төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн болон бусад орлогын 20... оны тайлан (З-ОУИТБС-4),
5. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, борлуулалтын 20... оны нэгдсэн тайлан (З-ОУИТБС-5),
6. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн орлогын 20... оны нэгтгэлийн тайлан (З-ОУИТБС-6)

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга /Т.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН